



НИЙСЛЭЛИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Байгууллагын зохион байгуулалтын бүтэц,
орон тоо, цалингийн хэмжээ, нэмэгдлийг
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 тогтоол, 2024 оны “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 84 дүгээр тогтоолын 1, 4 дүгээр хавсралт, 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоолын 3, 9, 10, 11 дүгээр хавсралт, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог нэгдүгээр, албан хаагчдын цалингийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллагын ажилтан, албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдэл, хоол унааны хөнгөлөлтийг хавсралтын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс холбогдох хууль, тогтоомжийн дагуу цалингийн зардлаас бодож олгохыг ахлах нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын 2024 оны Б/06 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.САРАНЦЭЦЭГ

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн
1/01 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ –
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

